



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/05

Ховд

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Авто машин худалдан авах /дэмжлэг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Ариунбилэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүдэд: Б.Далайбаяр - Эрүүл мэндийн газрын эдийн засагч

Дү.Одончимэг - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Т.Бат-Эрдэнэ - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Э.Цолмон - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Д.Ариунбилэг)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Цолмон)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

- 8400 03 0025  
D/Tush-A/05-Bo